

# ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Эрчим хүчний үндэсний төв ТӨХХК-ийн 2025 оны  
санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: САГ-2026/103/НА-СТА-ТӨҮГ

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)  
Улаанбаатар хот  
2026 он

Санхүүгийн аудитын газрын захирал,  
тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг  
Утас: 51-261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn  
Аудитын менежер Б.Долгорсүрэн  
Утас: 51-260512 Цахим хаяг: Dolgorsuren.b@audit.gov.mn  
Ахлах аудитор С.Отгонхорлоо  
Утас: 51-261628 Цахим хаяг: otgonkhorloos@audit.gov.mn  
Гроут финанс Аудит ХХК-ийн гүйцэтгэх захирал Б.Бямбадорж  
Утас: 77721628 Цахим хаяг: Vyambadorj@growthfinance.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

---

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....	2
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН.....	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА .....	11
АУДИТЫН ТАЙЛАН.....	15
4.1 Ерөнхий зүйл.....	15
4.2 Материаллаг байдал.....	15
Ерөнхий чиглэлийн судалгааны талаар:.....	15
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	16
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	16
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	16
4.5.1 Завсрын аудитын талаар .....	16
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	16
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....	18
5.1 Төлбөрийн акт.....	18
5.2 Албан шаардлага .....	19
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	22

### Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,  
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160  
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,  
Цахим шуудан: info@audit.gov.mn,  
Цахим хуудас: www.audit.mn

2026.03.23 № 06/770  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-г

ЭРЧИМ ХҮЧНИЙ ҮНДЭСНИЙ ТӨВ  
ТӨХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН  
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ Э.МӨНДӨР ТАНАА

### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Эрчим хүчний үндэсний төв ТӨХХК-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бүртгэлийн бодлого, тайлбар тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС)-ын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

### Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын олон улсын стандарт (АОУС), түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн дараах залруулагдаагүй зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд шинж чанарын хувьд материаллаг, дангаараа буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна. Тухайлбал:

- Тус компанийн эзэмшлийн 401.4 сая төгрөгийн өртөгтэй 4189 м2 газар, 110.0 сая төгрөгийн өртөгтэй 1149м2 газрууд дээр эрх бүхий байгууллагын шийдвэргүйгээр нийтийн зориулалттай орон сууц барьсан боловч санхүүгийн тайланд бүртгэлтэй хэвээр байна;
- Нийслэлийн Засаг Даргын 2024 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн А/1358 дугаар захирамжаар олгосон Хан-Уул дүүргийн 8 дугаар хороонд байрлах 4997м2 талбайтай 304.6 сая төгрөгийн үнэлгээ бүхий газар эзэмших эрхийг нягтлан бодох бүртгэлд тусгаагүй;
- Өөрийн үйл ажиллагаанд хамааралгүй, худалдан авах үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгаагүй нэвтрүүлэг, контентын үйлчилгээнд 141.7 сая төгрөгийн хөрөнгө зарцуулсан;

- Санхүүгийн тайланд бүртгэлтэй зорь, агуулах, хүлэмж, хашаа, дулааны шугам гэх мэт 8 нэр төрлийн 25.5 сая төгрөгийн хөрөнгө бодитоор оршин байхгүй байна.

### **Асуудлыг онцолсон хэсэг**

Эрчим хүчний сайдын 2022 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн А/215 дугаар тушаалаар баталсан “Төсөл, арга хэмжээний техник хяналтын зардал, тусгай зөвшөөрөл, цахилгаан, дулааны техникийн нөхцөл олголтын үйлчилгээний хураамжийг зарцуулах, тайлагнах журам”-ын зохицуулалтын хүрээнд тус компанийн үйл ажиллагаанд хамааралгүй 434.0 сая төгрөгийн зардал гарсныг хүлээн зөвшөөрч бүртгэсэн байна.

### **Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тус компанийн хувьд НББОУС 12 Орлогын албан татварт заасны дагуу орлогын албан татварын түр зөрүүгийн нөлөөг хүлээн зөвшөөрч, бүртгээгүй байна. Энэ нь үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацаа, элэгдэл тооцож эхлэх хугацаа, үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл, тооцоолсон орлого, зардал, бусад зүйлсийн хувьд үүсэх бөгөөд үзүүлэх нөлөө нь материаллаг бөгөөд болзошгүй нөхөн татвар, торгууль, алдангийн эрсдэлийг хүлээх нөхцөл болж байна.

### **Бусад асуудлын хэсэг**

Засгийн газрын 2022 оны 318 дугаар тогтоолоор Эрчим хүчний хөгжлийн төв ААТҮГ, Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төв ТӨҮГ-ыг нэгтгэн тус компанийг байгуулах үед шилжин ирсэн 3,019.5 сая төгрөгийн дахин үнэлгээний нэмэгдэл нь үндсэн хөрөнгийн тайланд тусгагдаагүй орхигдсоноос уг дансны дүн нь бодитой илэрхийлэгдээгүй бөгөөд мэдээллийн хязгаарлагдмал байдлаас шалтгаалан дүнг тодорхойлох боломжгүй байна.

### **Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

(Төгрөгөөр)

Үзүүлэлт	2024-12-31	2025-12-31
<b>ХӨРӨНГӨ</b>		
<b>Эргэлтийн хөрөнгө</b>		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	8,154,996,886.54	10,424,277,579.52
Дансны авлага	1,119,715,490.62	823,155,600.68
Татвар, НДШ-ийн авлага	-	0.01
Бусад авлага	9,576,792.56	431,531,821.97
Бараа материал	386,997,410.32	723,325,762.70
Урьдчилж төлсөн зардал, тооцоо	19,560,050.16	495,286,350.67
Бусад эргэлтийн хөрөнгө	-	-
<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>9,690,846,630.19</b>	<b>12,897,577,115.55</b>
<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>		
Үндсэн хөрөнгө	8,503,996,863.07	10,649,318,770.34
Биет бус хөрөнгө	91,372,937.91	73,116,834.45
Хойшлогдсон татварын хөрөнгө	-	-
Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө	-	-
Бусад эргэлтийн бус хөрөнгө	9,128,327,100.00	9,128,327,100.00
Дуусаагүй барилга	-	-
<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>17,723,696,900.98</b>	<b>19,850,762,704.79</b>
<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>27,414,543,531.17</b>	<b>32,748,339,820.34</b>
<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>		
<b>Өр төлбөр</b>		
<b>Богино хугацаат өр төлбөр</b>		
Дансны өглөг	410,802,174.92	653,590,000.87
Цалингийн өглөг	-	305,783,944.48
Татварын өр	1,166,179,255.82	1,461,271,922.15
НДШ-ийн өглөг	9,082,114.81	0.00
Урьдчилж орсон орлого	2,682,586,941.43	4,421,537,578.95
<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>4,268,650,486.97</b>	<b>6,842,183,446.45</b>
<b>Урт хугацаат өр төлбөр</b>		
Урт хугацаат зээл	-	-
Нөөц /өр төлбөр/ - Урт хугацаат	-	-
Хойшлогдсон татварын өр	-	30,948,020.15
Бусад урт хугацаат өр төлбөр	3,731,110,140.00	3,731,110,140.00
<b>Урт хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>3,731,110,140.00</b>	<b>3,762,058,160.15</b>
<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>7,999,760,626.97</b>	<b>10,604,241,606.60</b>
<b>Эздийн өмч</b>	<b>3,300,991,177.74</b>	<b>3,300,991,177.74</b>
Өмч: - төрийн	3,300,991,177.74	3,300,991,177.74
Халаасны хувьцаа	-	-
Нэмж төлөгдсөн капитал	-	-
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	3,019,474,302.61	3,019,474,302.61
Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	-	-
Эздийн өмчийн бусад хэсэг	10,523,738,721.57	10,523,738,721.57
Хуримтлагдсан ашиг (алдагдал)	(2,653,557,744.89)	2,614,963,058.28
Тайлант үеийн ашиг (алдагдал)	5,224,136,447.17	2,684,930,953.54
<b>Эздийн өмчийн дүн</b>	<b>19,414,782,904.20</b>	<b>22,144,098,213.74</b>
<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	<b>27,414,543,531.17</b>	<b>32,748,339,820.34</b>

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

(Төгрөгөөр)

№	ҮЗҮҮЛЭЛТ	2024-12-31	2025-12-31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	9,410,677,866.02	12,595,433,475.50
2	Борлуулалтын өртөг	38,440,782.66	43,966,769.20
<b>3</b>	<b>Нийт ашиг ( алдагдал)</b>	<b>9,372,237,083.36</b>	<b>12,551,466,706.31</b>
4	Түрээсийн орлого	-	-
5	Хүүний орлого	273,516,284.28	938,507,169.92
6	Ногдол ашгийн орлого	-	-
7	Эрхийн шимтгэлийн орлого	-	-
8	Бусад орлого	3,458,523,885.97	-
9	Борлуулалт, маркетингийн зардал	-	131,936,363.64
10	Ерөнхий ба удирдлагын зардал	7,325,611,764.50	9,886,144,062.22
11	Санхүүгийн зардал	-	-
12	Бусад зардал	-	403,233,616.85
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	(4,460,134.96)	18,192,530.30
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)	-	-
17	Бусад ашиг (алдагдал)	-	-
<b>18</b>	<b>Татвар төлөхийн өмнөх ашиг ( алдагдал)</b>	<b>5,774,205,354.16</b>	<b>3,086,852,363.81</b>
19	Орлогын татварын зардал	550,068,906.99	401,921,410.27
<b>20</b>	<b>Татварын дараах ашиг (алдагдал)</b>	<b>5,224,136,447.17</b>	<b>2,684,930,953.54</b>
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	-	-
<b>22</b>	<b>Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал)</b>	<b>5,224,136,447.17</b>	<b>2,684,930,953.54</b>
<b>23</b>	<b>Бусад дэлгэрэнгүй орлого</b>	<b>-</b>	<b>-</b>
23.1	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү	-	-
23.2	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-
23.3	Бусад олз (гарз)	-	-
<b>24</b>	<b>Орлогын нийт дүн</b>	<b>5,224,136,447.17</b>	<b>2,684,930,953.54</b>
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)		

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

(Төгрөгөөр)

ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
<b>2023-12-31-ний үлдэгдэл</b>	<b>3,300,991,177.74</b>	<b>3,019,474,302.61</b>	<b>14,279,770,721.57</b>	<b>(2,653,557,744.89)</b>	<b>17,946,678,457.03</b>
НББ-ийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-			-	-
<b>Залруулсан үлдэгдэл</b>	<b>3,300,991,177.74</b>	<b>3,019,474,302.61</b>	<b>14,279,770,721.57</b>	<b>(2,653,557,744.89)</b>	<b>17,946,678,457.03</b>
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-		5,224,136,447.17	5,224,136,447.17
Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-	-
Өмчид гарсан өөрчлөлт	-	-	(3,756,032,000.00)	-	(3,756,032,000.00)
Зарласан ногдол ашиг	-	-	-	-	-
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	-	-	-
<b>2024-12-31-ний үлдэгдэл</b>	<b>3,300,991,177.74</b>	<b>3,019,474,302.61</b>	<b>10,523,738,721.57</b>	<b>2,570,578,702.28</b>	<b>19,414,782,904.20</b>
НББ-ийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-			44,384,356.00	44,384,356.00
<b>Залруулсан үлдэгдэл</b>	<b>3,300,991,177.74</b>	<b>3,019,474,302.61</b>	<b>10,523,738,721.57</b>	<b>2,614,963,058.28</b>	<b>19,459,167,260.20</b>
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-		2,684,930,953.54	2,684,930,953.54
Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-	-
Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	-	-
Зарласан ногдол ашиг	-	-	-	-	-
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	-	-	-
<b>2025-12-31-ний үлдэгдэл</b>	<b>3,300,991,177.74</b>	<b>3,019,474,302.61</b>	<b>10,523,738,721.57</b>	<b>5,299,894,011.82</b>	<b>22,144,098,213.74</b>

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

(Төгрөгөөр)

№	ҮЗҮҮЛЭЛТ	2024-12-31	2025-12-31
1	<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
1.1	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>12,073,446,657.35</b>	<b>15,500,411,258.44</b>
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	11,987,238,804.35	15,446,208,607.96
	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	-	-
	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	-	-
	Буцаан авсан албан татвар	-	-
	Татаас, санхүүжилтийн орлого	-	-
	Бусад мөнгөн орлого	86,207,853.00	54,202,650.48
1.2	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>8,341,508,722.47</b>	<b>11,605,128,113.91</b>
	Ажиллагчдад төлсөн	2,887,753,022.91	3,806,414,844.64
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	928,108,887.35	1,245,411,439.95
	Бараа материал худалдан авахад төлсөн	177,736,178.56	243,086,308.43
	Ашиглалтын зардалд төлсөн	62,031,756.79	62,928,742.35
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	77,451,250.00	87,870,012.00
	Хүүний төлбөрт төлсөн	26,509,748.31	13,358,790.89
	Татварын байгууллагад төлсөн	1,053,191,351.03	1,229,860,311.74
	Даатгалын төлбөрт төлсөн	56,116,536.73	14,527,682.00
	Бусад мөнгөн зарлага	3,072,609,990.79	4,901,669,981.92
1.3	<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>3,731,937,934.88</b>	<b>3,895,283,144.53</b>
2	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
2.1	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>265,099,617.28</b>	<b>594,860,672.15</b>
	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	-	-
	Биет бус хөрөнгө борлуулсны орлого	-	-
	Хөрөнгө оруулалт борлуулсны орлого	-	-
	Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого	-	-
	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	-	-
	Хүлээн авсан хүүний орлого	265,099,617.28	594,860,672.15
	Бусад	-	-
2.2	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>621,171,616.00</b>	<b>2,239,055,654.00</b>
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	553,221,616.00	2,239,055,654.00
	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	67,950,000.00	-
	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	-	-
	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	-
	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	-	-
	Бусад	-	-
2.3	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(356,071,998.72)</b>	<b>(1,644,194,981.85)</b>
3	<b>Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
3.1	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	-	-
	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	-
	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	-
	Бусад	-	-
3.2	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>30,085,224.00</b>	-
	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	-	-
	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	-	-
	Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн	-	-

Эрчим хүчний үндэсний төв ХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

	Төлсөн ногдол ашиг	30,085,224.00	-
	Бусад	-	-
3.3	<b>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(30,085,224.00)</b>	<b>-</b>
	<b>Валютын ханшийн зөрүү</b>	<b>(4,460,134.95)</b>	<b>18,192,530.30</b>
4	<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>3,341,320,577.21</b>	<b>2,269,280,692.98</b>
5	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>4,813,676,309.33</b>	<b>8,154,996,886.54</b>
6	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>8,154,996,886.54</b>	<b>10,424,277,579.52</b>

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

№	Үзүүлэлт	Х/н	2024 оны гүйцэтгэл	2025 он		Харьцуулалт			
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл	2024 гүйц/ 2025 гүйц	Хувь	2025 төл/ 2025 гүйцэт	Хувь
<b>Бүтээгдэхүүн үйлдвэрлэлт гол нэр төрлөөр:</b>									
1	Захиалагчийн техник хяналтын орлого	м.төг	4,803,862.5	5,311,067.0	4,125,382.4	(678,480.1)	85.9	(1,185,684.6)	77.7
	Зураг төсөл магадлалын орлого	м.төг	722,231.3	700,000.0	910,305.2	188,073.9	126.0	210,305.2	130.0
	Сэргээгдэх эрчим хүчний орлого	м.төг	1,021,195.2	5,952,763.2	5,350,078.7	4,328,883.5	523.9	(602,684.5)	89.9
	Лабораторийн үйл ажиллагааны орлого	м.төг	542,782.0	650,000.0	756,247.7	213,465.6	139.3	106,247.7	116.3
	Тусгай зөвшөөрлийн орлого	м.төг	302,672.3	300,000.0	422,350.5	119,678.2	139.5	122,350.5	140.8
	Техникийн нөхцлийн орлого	м.төг	987,188.0	70,096.0	70,096.0	(917,092.0)	7.1	-	100.0
	Сургалтын орлого СУТ	м.төг	803,762.3	548,110.0	730,681.5	(73,080.7)	90.9	182,571.5	133.3
	Түрээсийн орлого	м.төг	95,127.3	92,400.0	95,127.3	-	100.0	2,727.3	103.0
	Хүүгийн орлого	м.төг	273,516.3	582,637.0	938,507.2	664,990.9	343.1	355,870.2	161.1
	Бусад орлого /Хэвлэх цех, ҮҮА /	м.төг	3,590,810.1	165,000.0	165,873.0	(3,424,937.1)	4.6	873.0	100.5
2	<b>Нийт орлого</b>	<b>м.төг</b>	<b>13,143,147.2</b>	<b>14,372,073.2</b>	<b>13,564,649.4</b>	<b>421,502.2</b>	<b>103.2</b>	<b>(807,423.8)</b>	<b>94.4</b>
3	<b>Нийт зардал</b>	<b>м.төг</b>	<b>7,368,941.9</b>	<b>12,932,437.3</b>	<b>10,477,797.0</b>	<b>3,108,855.2</b>	<b>142.2</b>	<b>(2,454,640.3)</b>	<b>81.0</b>
	Үүнээс: Удирдлагын зардал	м.төг	7,325,611.8	9,558,730.0	10,018,080.4	2,692,468.7	136.8	459,350.4	104.8
4	<b>Татварын өмнөх ашиг</b>	<b>м.төг</b>	<b>5,774,205.4</b>	<b>1,439,635.9</b>	<b>3,086,852.4</b>	<b>(2,687,353.0)</b>	<b>53.5</b>	<b>1,647,216.5</b>	<b>214.4</b>
5	<b>Цэвэр ашиг /алдагдал/</b>	<b>м.төг</b>	<b>5,224,136.4</b>	<b>1,295,666.0</b>	<b>2,684,931.0</b>	<b>(2,539,205.5)</b>	<b>51.4</b>	<b>1,389,265.0</b>	<b>207.2</b>
6	<b>Төсвийн төлбөрт нийт дүн</b>	<b>м.төг</b>	<b>1,252,351,610.8</b>	-	<b>2,469,717,307.7</b>	<b>1,217,365,696.9</b>	<b>197.2</b>	<b>2,469,717,307.7</b>	<b>-</b>
	а/ Орлогын татварт	м.төг	39,401,462.2	-	522,685,191.9	483,283,729.6	1,326.6	522,685,191.9	-
	б/ НӨТ	м.төг	58,111,434.2	-	280,815,264.1	222,703,829.9	483.2	280,815,264.1	-
	в/ НДШ	м.төг	841,306,531.1	-	1,245,411,440.0	404,104,908.9	148.0	1,245,411,440.0	-
	г/ Хүн амын орлогын татвар	м.төг	273,276,149.3	-	396,251,417.8	122,975,268.5	145.0	396,251,417.8	-
	д/ Үл хөдлөх хөрөнгийн татвар	м.төг	-	-	-	-	-	-	-
	э/ Тээврийн хэрэгслийн татвар	м.төг	1,071,331.0	-	3,450,822.0	2,379,491.0	322.1	3,450,822.0	-
	ж/ Бусад татварт (улсын тэмдэгтийн хураамж)	м.төг	39,184,703.0	-	21,103,172.0	(18,081,531.0)	53.9	21,103,172.0	-

Эрчим хүчний үндэсний төв ХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

7	Төрийн өмчийн ногдол ашгийн өглөг	м.төг	30,085,224.0		-	(30,085,224.0)	-	-	-
8	Нийт ажиллагсдын тоо	хүн	80.0	101.0	89.0	9.0	111.3	(12.0)	88.1
9	Нийт цалингийн сан	м.төг	3,206,543.0	4,900,578.7	4,675,695.2	1,469,152.1	145.8	(224,883.5)	95.4
10	Нэг ажиллагчийн дундаж цалин	м.төг	3,340.1	4,043.4	4,378.0	1,037.8	131.1	334.6	108.3
11	Борлуулалтын 1 төгрөгт ногдох зардал	м.төг	0.6	0.9	0.8	0.2	137.8	(0.1)	85.8
12	Хөрөнгө оруулалт	м.төг		4,558,477.5		-	-	(4,558,477.5)	-
13	<b>Нийт авлага</b>	<b>м.төг</b>	<b>1,129,292.3</b>	<b>958,887.0</b>	<b>1,254,687.4</b>	<b>125,395.1</b>	<b>111.1</b>	<b>295,800.4</b>	<b>130.8</b>
	Үүнээс: Найдваргүй	м.төг	416,828.4	392,733.6	-	(416,828.4)	-	(392,733.6)	-
14	<b>Нийт өглөг</b>	<b>м.төг</b>	<b>7,999,760.6</b>	<b>6,307,384.1</b>	<b>10,604,241.6</b>	<b>2,604,481.0</b>	<b>132.6</b>	<b>4,296,857.5</b>	<b>168.1</b>
	Богино хугацаат өр төлбөр	м.төг	4,268,650.5	2,576,274.0	6,842,183.4	2,573,533.0	160.3	4,265,909.4	265.6
	Урт хугацаат өр төлбөр	м.төг	3,731,110.1	3,731,110.1	3,762,058.2	30,948.0	100.8	30,948.1	100.8

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Компани, түүний үйл ажиллагаа

Эрчим хүчний үндэсний төв ТӨХХК-ийн эрхэм зорилгыг “Хүн төрөлхтний дэвшилт ололтыг дэмжин, сэргээгдэх эрчим хүчийг сурталчлан таниулах, нэвтрүүлэх, үндэсний хэмжээнд аюулгүй ажиллагааг эрхэмлэгч эрчим хүчний салбарын тэргүүлэгч байгууллага болох”-д оршино гэж тодорхойлсон байна.

Эрчим хүчний үндэсний төв ТӨХХК-ийн дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Эрчим хүчний салбарт улсын төсөв болон гадаад, дотоодын хөрөнгө оруулалт, зээл тусламжийн хөрөнгөөр хэрэгжих төсөл, арга хэмжээнд захиалагчийн үүрэг гүйцэтгэж, техникийн хяналт тавих;
- Эрчим хүчний барилга байгууламжийг барих, зөвлөх үйлчилгээний ажлын зураг төсөвт магадлал, шүүмж, дүгнэлт хийх, эдгээртэй холбоотой ажлыг зохион байгуулах;
- Салбарын хэмжээнд хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэхэд чиглэгдсэн сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх, салбарын хүний нөөцийг мэргэшүүлэх ажлыг зохион байгуулах, мэргэшлийн зэргийг аттестатчилах арга хэмжээг зохион байгуулах;
- Цахилгаан болон дулаанжуулалтын тоноглолын найдвартай байдлыг хангах зорилгоор түлш, уур ус, тос, металл судлал, гагнуурын хяналт шинжилгээ хийх, техникийн дүгнэлт гаргах;
- Эрчим хүчний шинэ эх үүсвэр, шугам сүлжээ барьж байгуулах, зуух, даралтат сав, шугам хоолойн угсралт, засвар үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход урьдчилсан дүгнэлт, үнэлгээ өгөх ажлыг зохион байгуулах;
- Эрхэлсэн асуудлаараа хууль тогтоомжийн хүрээнд гадаад, дотоодын болон олон улсын байгууллагуудтай хамтран ажиллах, гэрээ хэлэлцээр байгуулах, мэдээлэл солилцох;
- Компани техник хяналт тавигдсан эрчим хүчний барилга байгууламжийн техникийн хяналт, зураг төсөв, холбогдох материалаар мэдээллийн сан бүрдүүлэх, баяжуулах, сонирхогч байгууллага, иргэдийг энэ талын мэдээллээр хангах;
- Компанийн үндсэн болон хууль тогтоомжоор хориглоогүй бусад чиг үүргийг хэрэгжүүлэхэд чиглэгдсэн бизнесийн үйл ажиллагаа эрхлэх.

#### 3.2 Компанийн гадаад, дотоод орчин

Эрчим хүчний үндэсний төв ТӨХХК нь үйл ажиллагаандаа дараах эрхзүйн актыг мөрдөн ажиллаж байна. Үүнд:

- Компанийн тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль
- Нийгмийн даатгалын багц хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Татварын багц хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Эрчим хүчний тухай хууль
- Эрчим хүчний салбарын хамтын хэлэлцээр

Тайлант хугацаанд компанийн үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Татварын ерөнхий хууль
- Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль
- Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль
- Хувь хүний орлогын албан татварын тухай хууль
- Эрчим хүчний салбарын хамтын хэлэлцээр

Компанийн удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна гэж үнэллээ.

Дотоод аудит, аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Эрчим хүчний үндэсний төв ТӨХХК-ийн 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг *аккруэл* сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус компанийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь дор дурдсанаас бусад зүйлсийн хувьд холбогдох хууль тогтоомж, санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна. Үүнд:

- НББОУС 12 “Орлогын албан татвар”-т холбогдох зүйлс;
- СТОУС 15 “Худалдан авагчидтай байгуулсан гэрээний орлого” -т холбогдох зүйлс;
- СТОУС 16 “Түрээс” -т холбогдох зүйлс;

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт

Эрчим хүчний үндэсний төв ТӨХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан аж ахуйн нэгжид мөрдөгдөх “Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд тус компанийн нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна. Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 5,333.8 сая төгрөгөөр буюу 19.5 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

(мянган төгрөгөөр)

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт	Хувь
Багана	1	2	3=2-1	4
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	8,154,996.9	10,424,277.6	2,269,280.7	27.8
Авлага	1,129,292.3	1,254,687.4	125,395.1	11.1
Бараа материал	386,997.4	723,325.8	336,328.4	86.9
Урьдчилж төлсөн зардал, тооцоо	19,560.1	495,286.4	475,726.3	2,432.1
Үндсэн хөрөнгө	8,503,996.9	10,649,318.8	2,145,321.9	25.2
Биет бус хөрөнгө	91,372.9	73,116.8	(18,256.1)	(20.0)
Бусад эргэлтийн бус хөрөнгө	9,128,327.1	9,128,327.1	-	-
<b>Нийт хөрөнгийн дүн</b>	<b>27,414,543.5</b>	<b>32,748,339.8</b>	<b>5,333,796.3</b>	<b>19.5</b>
Богино хугацаат өр төлбөрийн дүн	4,268,650.5	6,842,183.4	2,573,533.0	60.3
Урт хугацаат өр төлбөрийн дүн	3,731,110.1	3,762,058.2	30,948.0	0.8
Өмч: - төрийн	3,300,991.2	3,300,991.2	-	-
Эздийн өмчийн бусад хэсэг	10,523,738.7	10,523,738.7	-	-
Хуримтлагдсан ашиг (алдагдал)	2,570,578.7	5,299,894.0		106.2
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	3,019,474.3	3,019,474.3	-	-
<b>Өр төлбөр, цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>27,414,543.5</b>	<b>32,748,339.8</b>	<b>5,333,796.3</b>	<b>19.5</b>

Хүснэгтээс харахад тайлант онд дараах данснуудад нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна. Үүнд:

- Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө дансны үлдэгдэл 10,424.3 сая төгрөг болж, 2,269.3 сая төгрөгөөр буюу 27.8 хувиар нэмэгджээ. Энэ нь бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого 3,459.0 сая төгрөгөөр буюу 28.9 хувиар өссөнтэй холбоотой байна;
- Бараа материалын дансны үлдэгдэл 723.3 сая төгрөг болж, 336.3 сая төгрөгөөр буюу 86.9 хувиар нэмэгдсэнээс лабораторийн материал 235.3 сая төгрөгөөр, хангамжийн материал 62.7 сая төгрөгөөр, аж ахуйн материал 14.3 сая төгрөгөөр тус тус өссөн нь нийт өсөлтийн 92.8 хувийг эзэлж байна.
- Урьдчилж төлсөн зардал, тооцоо дансны үлдэгдэл 495.3 сая төгрөг болж, 475.7 сая төгрөгөөр буюу 2,432.1 хувиар нэмэгджээ. Бэлтгэн нийлүүлэгчид төлсөн урьдчилгаа данс 417.8 сая төгрөгөөр, албан томилолтын тооцоо данс 48.5 сая төгрөгөөр, шатахууны тооцоо данс 9.3 сая төгрөгийн өсөлттэй байна. Ашид профит трейд ХХК-д шилжүүлсэн 98.0 сая төгрөг, Инженер Геологи Номт ХХК-д шилжүүлсэн 96.9 сая төгрөг, Боригтэс ХХК-д шилжүүлсэн 73.0 сая төгрөг, Энержи бөх бат ХХК-д шилжүүлсэн 37.2 сая төгрөгүүдийн дүн нь бэлтгэн нийлүүлэгчид төлсөн урьдчилгаа дансны үлдэгдлийн 61.6 хувийг эзэлж байна.
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 10,649.3 сая төгрөг болж, 2,145.3 сая төгрөгөөр буюу 25.2 хувиар нэмэгджээ. Тайлант онд 2,703.4 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн худалдан авалт их засварыг хийсэн нь хөрөнгийн дүн өсөх шалтгаан болжээ. Тухайлбал: Барилга, байгууламж 925.5 сая төгрөгөөр, машин, тоног төхөөрөмж 917.3 сая төгрөгөөр, тээврийн хэрэгсэл 708.4 сая төгрөгөөр, компьютер, дагалдах хэрэгсэл 132.2 сая төгрөгөөр, тавилга эд хогшил 19.9 сая төгрөгөөр тус тус худалдан авчээ. ТӨБЗГ-ын 2025 оны 7 дугаар сарын 08-ны өдрийн 397 дугаар тогтоолын дагуу 154.1 сая төгрөгийн анхны өртөг бүхий элэгдлээрээ өртгөө нөхсөн хөрөнгүүдийг данснаас хасжээ.
- Богино хугацаат өр төлбөрийн үлдэгдэл 6,842.2 сая төгрөг болж 2,573.5 сая төгрөгөөр буюу 60.3 хувиар нэмэгджээ. Урьдчилж орсон орлого 1,738.9 сая төгрөгөөр, цалингийн өглөг 305.8 сая төгрөгөөр, татварын өр 295.1 сая төгрөгөөр, дансны өглөг 242.8 сая төгрөгөөр тус тус өссөн бол нийгмийн даатгалын шимтгэлийн өр 9.1 сая төгрөгөөр буурчээ.
- Эздийн өмчийн дүн 2,729.3 сая төгрөгөөр өссөн нь тайлант үеийн цэвэр ашиг 2,684.9 сая төгрөг болон өмнөх үеийн алдааны залруулга 44.4 сая төгрөгтэй холбоотой байлаа.

### 3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Эрчим хүчний үндэсний төв ТӨХХК нь үйлдвэрлэл, зорилтот түвшний төлөвлөгөөг боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Эрчим хүчний сайдын 2025 оны А/353 дугаар тушаалаар 2025 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан байна. Тайлант оны нийт орлогыг 14,372.1 сая төгрөгөөр, нийт зардлыг 13,076.4 сая төгрөгөөр, 1,295.7 сая төгрөгийн ашигтай ажиллахаар тодотгон баталсан байна. Үүнээс хөрөнгө оруулалтын арга хэмжээнд 4,558.5 сая төгрөгийг төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр 13,564.6 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 10,477.8 сая төгрөгийн зардал гаргаж, 3,086.9 сая төгрөгийн татварын өмнөх ашигтай ажилласан байна.

Нийт орлогын гүйцэтгэл 13,564.6 сая төгрөг болж, төлөвлөснөөс 807.4 сая төгрөг буюу 5.6 хувиар тасарсан нь захиалагчийн техник хяналтын орлого 1,185.7 сая төгрөгөөр, сэргээгдэх эрчим хүчний орлого 602.7 сая төгрөгөөр тус тус тасалдсанаас шалтгаалжээ. Энэ нь төлөвлөгөөт зарим гэрээт ажлуудын санхүүжилт он дамжсан болон он дамжиж хийгдсэнтэй холбоотой байна.

Нийт зардлын гүйцэтгэл 10,477.8 сая төгрөг болж, төлөвлөснөөс 2,454.6 сая төгрөгөөр дутуу буюу 81.0 хувийн гүйцэтгэлтэй байна. Энэ нь ажиллагсдын нийгмийн арга хэмжээний зардлыг 660,0 сая төгрөг, судалгаа хөгжүүлэлтийн зардлыг 304.5 сая төгрөг, цалингийн зардлыг 224.8

сая төгрөг, элэгдлийн зардлыг 242.9 сая төгрөгөөр тус тус хэмнэсэн нь гол нөлөө үзүүлсэн байна.

Их засвар, хөрөнгө оруулалт, техник зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөгөөний дагуу 18 нэр төрлийн ажилд өөрийн эх үүсвэрээс 3,754.1 сая төгрөгийн зардлыг санхүүжүүлсэн байна.

Тайлант онд цэвэр ашиг 2,684.9 сая төгрөг болж, төлөвлөснөөс 1,389.3 сая төгрөгөөр илүү байгаа нь зардлын хэмнэлт нь орлогын тасралтаас давсан нь нөлөөлжээ.

ТӨБЗГ-т тайлант онд түрээсийн орлогын 40.0 хувь буюу 41.9 сая төгрөгийг төвлөрүүлжээ.

## АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Эрчим хүчний үндэсний төв ТӨХХК-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн компани, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн компанийн үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Гроут финанс Аудит ХХК-ийн аудитор Э.Нарангэрэл, С.Баяртогтох, Б.Хонгорзул нар гүйцэтгэж, чанарын хяналтын менежер Ч.Хүнбиш, гүйцэтгэх захирал Б.Бямбадорж нар анхан шатны хяналтыг, Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор С.Отгонхорлоо, аудитын менежер Б.Долгорсүрэн, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар дараагийн шатны чанарын хяналтыг тус тус хэрэгжүүлсэн.

Эрчим хүчний үндэсний төв ТӨХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланг Үндэсний аудитын газарт 2026 оны 2 дугаар сарын 13-ны өдрийн 1/283 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны нийт зардлын 7,918.6 сая төгрөгийн 1.0 хувь буюу 79.2 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тус компани 101 орон тоотой ажиллахаас 12 орон тоо дутуу ажиллаж, 224.9 сая төгрөгийг хэмнэж ажилласан байна.

#### Ерөнхий чиглэлийн судалгааны талаар:

Санхүүгийн тайлан аудитад баримтлах ерөнхий чиглэлийн дагуу судалгаа авч үр дүнг нэгтгэн дүгнэлээ. Үүнд:

- Эрчим хүчний үндэсний төв ТӨХХК-ийн дүрмийн 9.9.10, Эрчим хүчний үндэсний төв ТӨХХК, Үйлдвэрчний эвлэлийн хороотой 2023-2024 онд байгуулсан "Хамтын гэрээ"-ний 5 дугаар зүйлийн 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн хоолны мөнгө өдрийн 10,000 төгрөгөөр, унааны мөнгө өдрийн 2,000 төгрөгөөр тооцон олгосон бөгөөд 2025 онд хоолны хөнгөлөлтөд 171.3 сая төгрөг, унааны хөнгөлөлтөд 34.2 сая төгрөг олгож, 87.8 хувийн гүйцэтгэлтэй буюу 28.7 сая төгрөг хэмнэжээ.
- Тайлант онд тус компанид хамаарах 274.5 сая төгрөгийн гадаад албан томилолтын зардал гаргасан байна. Эрчим хүчний яамтай холбогдох 327.9 сая төгрөгийн гадаад томилолтын зардал гаргасан байна. Энэ нь Эрчим хүчний сайдын 2022 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн А/215 дугаар тушаалаар баталсан “Төсөл, арга хэмжээний техник хяналтын зардал, тусгай зөвшөөрөл, цахилгаан, дулааны техникийн нөхцөл олголтын үйлчилгээний хураамжийг зарцуулах, тайлагнах журам”-аар зохицуулагдсан байна.
- Төрд учирсан хохирлыг барагдуулахтай холбоотой зардал 2025 онд гараагүй байна.
- Тус компанид 169.7 сая төгрөгийн 13 программ хангамж бүртгэлтэй байна. Үүнээс 5.4 сая төгрөгийн анхны өртөг, 1.4 сая төгрөгийн дансны үнэ бүхий Санхүүгийн Юникус программыг үйл ажиллагаанд ашигладаггүй байна.

- Сургалт, семинар, хурал, зөвлөгөөнд 27.9 сая төгрөгийг зарцуулсан нь төсөвлөснөөс 9.6 сая төгрөгөөр хэтэрч, 152.1 хувийн гүйцэтгэлтэй байна.
- Тус компанийн хувьцааны 66.0 хувийг Эрчим хүчний яам, 34.0 хувийг Эрчист Монгол ТӨХХК эзэмшдэг байна.
- Тус компани нь 101 орон тоотой ажиллахаас тайлант онд 89 орон тоотой ажиллаж, орон тооны цомхотгол хийгээгүй байна.
- Өөрийн үйл ажиллагаанд хамааралгүй, худалдан авах үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгаагүй нэвтрүүлэг, контентын үйлчилгээнд 141.7 сая төгрөг зарцуулсан байна.

#### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тус компани нь нь тайлант хугацаанд шилэн дансанд оруулбал зохих 155 мэдээллээс 154 мэдээллийг хугацаанд нь, 1 мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан байна.

Шийдвэрлэсэн нь: .

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар компанийн 2025 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланг хамруулж, холбогдох данстын хувьд горим, сорил хэрэгжүүлж, нийт 3,718.7 сая төгрөгийн 7 алдаа, 607.6 сая төгрөгийн 5 зөрчил илрүүлснийг асуудлын бүртгэлээр шалгагдагч байгууллагад танилцуулж, баталгаажуулсан.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар зөрчлийг арилгах 542.5 сая төгрөгийн 6 албан шаардлага, 15.0 сая төгрөгийн 3 зөвлөмж өгснийг нотлох баримтад үндэслэн хянаж үнэлэхэд 95.6 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт 2. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

(мянган төгрөгөөр)

Үзүүлэлт	Өмнөх аудитаар өгсөн		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	-	-	-	-	-
Албан шаардлага	6	542,533.6	6	542,533.6	100.0
Зөвлөмж	3	15,000.0	2.6	-	86.7
<b>Нийт дүн</b>	<b>9</b>	<b>557,533.6</b>	<b>7</b>	<b>442,733.6</b>	<b>95.6</b>

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар дараах асуудлуудыг анхаарч үзэх шаардлагатай гэж үзлээ. Үүнд:

- Эрчим хүчний сайдын 2022 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн А/215 дугаар тушаалаар баталсан “Төсөл, арга хэмжээ ний техник хяналтын зардал, тусгай зөвшөөрөл, цахилгаан, дулааны техникийн нөхцөл олголтын үйлчилгээний хураамжийг зарцуулах, тайлагнах журам” нь хуульд нийцэж буй эсэх талаар шалгах, тус журмын дагуу Эрчим хүчний яам, УИХ-ын гишүүдийн дотоод, гадаад томилолтын зардлыг тус компанийн зардлаар хүлээн зөвшөөрч тайлагнаж байгаа нь зардал давхардах, төсөв үр ашиггүй зарцуулагдах өндөр эрсдэл бүхий буйг анхаарах.
- Эрчим хүчний үндэсний төв ТӨХХК, Багануурын цахилгаан станц төсөл хэрэгжүүлэгчийн нэгж, Багануур пауэр ХХК-ийн хооронд 2025 оны 02 дугаар сарын 26-ны өдөр байгуулсан “Техник хяналтын төлбөрийг найм дахь удаагийн урьдчилан төлөх гэрээ”-ний дагуу Багануурын цахилгаан станц төсөл хэрэгжүүлэгчийн нэгжид шилжүүлж, зардлаар бүртгэсэн 90.0 сая төгрөгийн төгрөгийн зарцуулалтыг шалгах.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 4,220.8 сая төгрөгийн алдаа<sup>1</sup> илэрснээс аудитын явцад 1,201.4 сая төгрөгийн 4 алдааг залруулж, 3,019.5 сая төгрөгийн алдааг дахин давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө.

### Залруулсан алдаа:

- Компани нь татвар ногдуулах орлогыг дутуу, татвар ногдох орлогоос хасагдах зардлыг илүү тайлагнасан зэргээс шалтгаалан 2025 оны орлогын албан татварыг 157.7 сая төгрөгөөр, татварын ногдлыг 122.2 сая төгрөгөөр, хойшлогдсон татварын өр төлбөрийг 30.9 сая төгрөгөөр тус тус дутуу тайлагнасан нь НББОУС 1 "Санхүүгийн тайлангийн толилуулга" заалт 15 "Санхүүгийн тайланд аж ахуйн нэгжийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг үнэн зөв толилуулах ёстой" болон санхүүгийн тайлагналын үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна;
- Борлуулалтын орлогыг санхүүгийн тайланд 692.6 сая төгрөгөөр дутуу тайлагнасан нь НББОУС 1 "Санхүүгийн тайлангийн толилуулга" заалт 15 "Санхүүгийн тайланд аж ахуйн нэгжийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг үнэн зөв толилуулах ёстой" болон санхүүгийн тайлагналын үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна;
- Аккруэл сууриар орлого хүлээн зөвшөөрөөгүйгээс хадгаламжийн хүүгийн орлого, хүүгийн авлагыг 291.3 сая төгрөгөөр дутуу тайлагнасан нь НББОУС 1 "Санхүүгийн тайлангийн толилуулга" заалт 15 "Санхүүгийн тайланд аж ахуйн нэгжийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг үнэн зөв толилуулах ёстой" болон санхүүгийн тайлагналын үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна;
